




ЭКСПО МОНГОЛИА

УУЛ УУРХАЙ БОЛОН БУСАД САЛБАРЫН
ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН ОЛОН УЛСЫН
БАГА ХУРАЛ, ҮЗЭСГЭЛЭН



Монгол улсын Ирээдүйн Төлөө


ҮЗЭСГЭЛЭНГИЙН ДАРААХ ТАЙЛАН

2015 оны 3-р сарын 23 – 25
Улаанбаатар хот

Экспо Монголиа 2015 - Үзэсгэлэнгийн дараах тайлан



УУЛ УУРХАЙ БОЛОН БУСАД САЛБАРЫН
ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН ОЛОН УЛСЫН
ХУРАЛ, ҮЗЭСГЭЛЭН



Огноо | Байршил

2015 оны 3-р сарын 23-аас 25-нд
Буянт-Ухаа Спортын Ордон, Улаанбаатар хот
Монгол Улс

Үзэсгэлэнд оролцогчид

10 улсаас оролцсон 80 компани:
Австри, Бельги, БНЧУ, Франц, Герман,
Итали, Монгол, Польш, Орос, Сингапур

Зочид

Монгол болон хөрш зэргэлдээх улсуудаас ирсэн
2.153 мэргэжилтэн, төлөөлөгчид

Хамрагдсан салбарууд

Хөдөө аж ахуй, Барилга байгууламж, Эрчим хүч,
Боловсрол, Дэд бүтэц, Логистик, Хэвлэл мэдээлэл,
Уул уурхай, Тээвэрлэлт, Үйлчилгээ




Дэмжигч яамдууд

Эрчим хүчний Яам
Байгаль орчин, Ногоон хөгжлийн Яам
Уул уурхайн Яам
Зам, Тээврийн Яам



Дотоодын дэмжигч байгууллагууд

Улаанбаатар хот
Монголын Үндэсний Худалдаа Аж үйлдвэрийн Танхим
Монголын Бизнесийн Зөвлөл
Төрийн Өмчийн Хороо



Олон улсын дэмжигч байгууллагууд

ASSOCIM – Итали-Монголын Худалдаа Аж Үйлдвэрийн
Танхим
Чехийн Трейд
Герман-Монголын Бизнес Эрхлэгчдийн Холбоо
Монгол Германы хамтарсан Ашигт малтмал,
Технологийн Их сургууль
VDMA – Германы Машин механизм үйлдвэрлэлийн
байгууламжийн Холбоо





УУЛ УУРХАЙ БОЛОН БУСАД САЛБАРЫН
ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН ОЛОН УЛСЫН
ХУРАЛ, ҮЗЭСГЭЛЭН

Экспо Монголиа 2015 - Үзэсгэлэнгийн дараах тайлан



Хэвлэл мэдээллийн дэмжигчид

Броадбэнд ХХК
Форбес Сэтгүүл
Монгол Майнинг Журнал
Монгол Ньюс Групп
Оксфорд Бизнес Групп
Улаанбаатар Шуудан

Бусад дэмжигчид

Чингис Хаан ОУНОБ
Бэст Вестерн Зочид Буудал
Корпорайт Зочид Буудал
Кэмпински Зочид Буудал



Экспо Монголиа Нээлтийн Үйл ажиллагаанд хүрэлцэн ирсэн зочид

- ☒ Монгол Улсын Сайд М. Энхсайхан
- ☒ ХБНГУ-ын Элчин Сайд Ноён Герхард Тийдэманн
- ☒ Франц улсын Элчин Сайд Ноён Ив Дэлунэ
- ☒ БНЧУ-ын Ерөнхий Сайд Хатагтай Ивана Гроллова
- ☒ Эрчин Хүчний Яамны Төрийн Нарийн бичгийн дарга Ноён Д. Дэлгэрцогт
- ☒ Нийслэлийн Засаг даргын орлогч Ноён Ц. Энхцэнгэл
- ☒ Монголын Үндэсний Худалдаа Аж үйлдвэрийн Танхимын Захирал Хатагтай М. Оюунчимэг



Гурван өдөр үргэлжилсэн олон улсын хурал зөвлөгөөнд

БНЧУ, Герман, Монгол болон ОХУ-ын төлөөлөгчид барилга байгууламж, боловсрол, хөрөнгө оруулалт, уул уурхай, тээвэрлэлт, зэрэг сэдвүүдээр илтгэл тавьж оролцсон.



Дараагийн Үзэсгэлэнгийн Огноо

2016 оны 5-р сарын 23-наас 25-нд
Буянт-Ухаа Спортын Ордон, Улаанбаатар хот, Монгол Улс

Зохион байгуулагч

Экспо Монголиа 21 LLC & Ёот Фау Консалт ХХК

Олон Улсад холбоо барих

Экспо Монголиа 21 LLC
Хатагтай Лиза Мойллер
Утас: +49 40 710070-32
И-Мэйл: info@expomongolia.com



Монгол Улсад холбоо барих

Ёот Фау Консалт ХХК
Хатагтай Д. Нарангиймаа
Утас: +976 94009471
И-Мэйл: em@expomongolia.com

“Экспо Монголиа 2015” Амжилтын гараа!

**3-р сарын 23-25-нд
Буянт-Ухаа Спортын Ордонд**



2015 оны 3 сарын 23-аас 25-ны өдрүүдэд Экспо Монголиа үзэсгэлэн, бага хурлын үеэр хөдөө аж ахуй, дэд бүтэц, барилга байгууламж, эрчим хүч, уул уурхай болон тээврийн салбаруудаас 80-аад дотоод, гадаадын компани, байгууллагууд оролцож, хамгийн сүүлийн үеийн бүтээгдэхүүнээ танилцууллаа. Уг үзэсгэлэнд гурван өдрийн турш Монгол улсаас гадна хөрш зэргэлдээх улс орнуудаас 2,153 мэргэжилтэнгүүд зочилон ирсэн.

Тус үзэсгэлэнг Монгол улсын Сайд М. Энхсайхан нээж, Монгол улсын гадаад харилцаа болон худалдааг нэмэгдүүлэхэд уг үзэсгэлэн жинтэй хувь нэмэр оруулж буйг онцлон илэрхийлсэн билээ. Түүнчлэн ХБНГУ-ын Элчин Сайд Ноён Герхард Тийдэманн, БНЧУ-ын Элчин Сайд Хатагтай Ивана Гроллова, Эрчим хүчний Яамны Төрийн Нарийн бичгийн Дарга Д. Дэлгэрцогт болон бусад албан тушаалтан, төр засгийн төлөөлөгчид нээлтийн арга хэмжээнд оролцон үг хэлсэн ба “Экспо Монголиа” нь Монгол улс дах урдаа барьсан олон улсын үзэсгэлэн гэж сайшаасан.

Үзэсгэлэнд оролцогчид “Экспо Монголиа” үзэсгэлэнг ирээдүйн хамтрагчтайгаа танилцах тавцангаа болгон аж үйлдвэр эрхлэгчид, хувьцаа эзэмшигчид болон засгийн газрын байгууллагуудтай харилцаа холбоо үүсгэх, нөөц баялагаар дүүрэн Монгол улсад бизнесээ өргөжүүлэх боломжуудыг олж авсан.

Олон жилийн хамтын ажиллагааны түншлэл нь Германы экспорт, ханган нийлүүлэгчдэд зүүн Азийн бүсэд бизнесээ өсгөн нэмэгдүүлэх боломжийг нээж өгч байгаа юм. Герман улсын уул уурхай, барилга байгууламж, хөдөө аж ахуй, анагаах ухааны салбар дахь туршлага, чадварыг Монгол улсад нэвтрүүлэх нь нэн чухал ач холбогдолтой билээ. Германы компаниуд ХБНГУ-ын Эдийн засгийн хамтын ажиллагаа, Эрчим хүчний яам, мөн дэлхийд алдартай хамгийн том VDMA-Хүнд машин механизм үйлдвэрлэгчдийн инженерүүдийн Холбооны дэмжлэгтэйгээр үзэсгэлэнд оролцох боломжийг олж авсан. Энэ боломжийг ашиглан нийт 35 компани Монгол улсын зах зээлд хөл тавьж чадсан юм.

Монгол улс дахь БНЧУ-ын Элчин сайдын Яам болон “Чех Трейд -Худалдааны агентлаг” хамтран хамгийн анхны удаа үндэсний павилон үүсгэн “Экспо Монголиа” үзэсгэлэнд нэгдсэн нь тус үзэсгэлэн Европын улсуудын сонирхолыг ихээр татсаныг илтгэж чадсан билээ.

Хүрэлцэн ирсэн зочид төлөөлөгчид, үзэсгэлэнгийн үеэр зохион байгуулагддаг хурал зөвлөгөөнд идэвхитэй оролцож хөрөнгө оруулалтын боломж бололцоо, төрөл бүрийн уул уурхайн болон эрчим хүчний талаарх сэдвүүд түүнчлэн үндэсний гол чухал сэдэв болох дэд бүтцийн төслүүдийн талаар мэдээллийг авсан. Эдгээр илтгэлүүдийг Эрчим хүчний Яам, Уул уурхайн Яам, Инвест Монголиа Агентлаг, Монголын Үндэсний Худалдаа Аж үйлдвэрийн Танхим болон гадаадын үзэсгэлэнд оролцогчид амжилттай хийлээ.

Ирэх жилийн Экспо Монголиа нь 2016 оны 5-р сарын 23-наас 25-ны өдрүүдэд зохион байгуулагдана.

Дэлгэрэнгүй мэдээллийг манай веб хуудаснаас хүлээн авна уу.

www.expomongolia.com

Зохион байгуулагчийн танилцуулга

“Экспо Монголиа” үзэсгэлэн нь Монгол дах “Ёот Фау Консалт” ХХК болон “Экспо Монголиа 21” LLC (Ёот Фау Консалт Мэссэменежмент, Планетфейр Группын хамтын эзэмшил)–н олон улсын үзэсгэлэнгийн салбарт туршлага хуримтлуулсан урт хугацааны хамтын ажиллагаан дээр суурилан зохион байгуулагддаг.

“Планетфейр Групп” нь ХБНГУ-ын Хамбург болон Дубай хотноо байрлаж дэлхий даяар жил бүр 25 үзэсгэлэн худалдааг зохион байгуулдаг бол “Ёот Фау Консалт Мэссэменежмент” нь албан газар, үзэсгэлэнд оролцогч болон зохион байгуулагчдад үзэсгэлэнтэй холбоотой бүхий л үйлчилгээг явуулдаг, олон улсын үзэсгэлэнгийн салбарт 30 жилийн туршлагыг хуримтлуулсан компани билээ. Ёот Фау Консалт нь Монгол улсад 2010 оноос хойш үйл ажиллагаагаа явуулж эхлэсэн бөгөөд Монгол усад олон улсын үзэсгэлэнг хамгийн анхны удаа зохион байгуулж байсан юм.

Огноо | Цагийн хуваарь

2016 оны 5-р сарын 23-аас 25-нд | Өдөр бүр 10.00 - 18.00

Байршил

Буянт-Ухаа Спортын Ордон, Улаанбаатар хот, Монгол Улс

Холбоо барих

Экспо Монгол 21 LLC
Яаррес гудамж 42
22303 Хамбург хот
ХБНГУ

Утас: +49 40 710070-32
info@expomongolia.com
www.expomongolia.com

Ёот Фау Консалт ХХК
Экспресс Цамхаг, 15 давхар
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот
Монгол Улс

Утас: +976 70009471
em@expomongolia.com
www.expomongolia.com



ЭКСПО МОНГОЛИА

УУЛ УУРХАЙ БОЛОН БУСАД САЛБАРЫН
ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН ОЛОН УЛСЫН
ХУРАЛ, ҮЗЭСГЭЛЭН

2016 оны 5 сарын 23-25 нд